НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чингэлтэй Нэгдсэн Эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/040/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Я.Алтанцэцэг<br>Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Анализ старт Аудит ХХК-ийн захирал Н.Энхтуяа<br>Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com |
| | |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ....................2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ....................4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....................**Error! Bookmark not defined.**
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ....................**Error! Bookmark not defined.**
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....................**Error! Bookmark not defined.**
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................**Error! Bookmark not defined.**
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ....................**Error! Bookmark not defined.**
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....................**Error! Bookmark not defined.**
4. АУДИТЫН ТАЙЛАН....................**Error! Bookmark not defined.**
4.1 Ерөнхий зүйл....................**Error! Bookmark not defined.**
4.2 Материаллаг байдал ....................**Error! Bookmark not defined.**
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....................**Error! Bookmark not defined.**
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................**Error! Bookmark not defined.**
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**Error! Bookmark not defined.**
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....................**Error! Bookmark not defined.**
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....................12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....................14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НА | Нотлох ажил |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НДШ | Нийгмийн Даатгалын Шимтгэл |
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| НШШГГ | Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМДЕГ | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 342

танай ______-ны № ______-т

ЧИНГЭЛТЭЙ НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ
Х.ГАНЦЭЦЭГ ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чингэлтэй Нэгдсэн Эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Чингэлтэй дүүргийн засаг даргын 2025 оны А/248 тоот захирамжаар Чингэлтэй нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 9 гишүүнийг батламжилсан ба НЭМГазрын даргын А/97 тоот тушаалаар тус байгууллага нь Нэгдсэн эмнэлэг болж өөрчлөгдсөн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллага нь ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолын дагуу ЭМДЕГ-тай хийгдсэн гэрээнд төлөвлөгөөт ангиллын тусламжийг сарын хуваариас хэтэрсэн тохиолдлын 20 хувиар хязгаарлалттайгаар санхүүжүүлснээр тайлант онд цахим хасагдалаар 800.9 сая төгрөгийн орлогыг хасуулсан байна.

**Бусад асуудал**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 117 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,755,347,954.76** | **2,589,599,601.66** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 10,011,674.04 | 132,170,529.78 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 10,011,674.04 | 132,170,529.78 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 10,011,674.04 | 132,170,529.78 |
| **33** | **АВЛАГА** | 1,032,851,376.47 | 1,171,656,785.98 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 1,100,333.44 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 1,004,083,686.04 | 1,060,643,778.61 |
| **335** | **Бусад авлага** | 28,767,690.43 | 109,912,673.93 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 511,625.50 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 28,767,690.43 | 109,401,048.43 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,712,484,904.25 | 1,285,772,285.90 |
| **351** | **Түүхий эд материал** | 803,539,679.43 | 437,093,734.75 |
| 35130 | Эм боох материал | 803,539,679.43 | 437,093,734.75 |
| **354** | **Хангамжийн материал** | 908,945,224.82 | 848,678,551.15 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,229,570.00 | 5,831,470.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 306,057,385.71 | 204,752,635.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 580,203,431.11 | 625,058,228.15 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 314,500.00 | 5,020,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 19,140,338.00 | 8,016,218.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,513,396,626.08** | **10,838,331,238.88** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 6,513,396,626.08 | 10,838,331,238.88 |
| **392** | **Биет хөрөнгө** | 6,259,761,425.55 | 10,580,740,572.18 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,844,655,235.20 | 5,180,228,931.20 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (2,837,712,868.16) | (2,958,580,396.45) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 443,892,000.00 | 443,892,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (222,583,363.78) | (267,104,792.26) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 11,271,897,803.44 | 12,290,571,300.62 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (7,300,740,331.61) | (4,347,619,526.49) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 379,669,514.58 | 236,328,272.56 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (320,964,884.48) | (80,268,962.00) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 47,624,150.00 | 83,464,145.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (45,975,829.64) | (170,400.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 253,635,200.53 | 257,590,666.70 |
| 39301 | Програм хангамж | 8,837,061.00 | 4,600,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (8,575,860.47) | (383,333.30) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 253,374,000.00 | 253,374,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **9,268,744,580.84** | **13,427,930,840.54** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,699,734,792.39** | **5,572,793,072.15** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 2,699,734,792.39 | 5,572,793,072.15 |
| **413** | **Өглөг** | 2,699,734,792.39 | 5,572,793,072.15 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 472,545,057.76 | 2,433,496,806.78 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,872,793,143.33 | 2,717,479,058.59 |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 9,834,800.00 | 81,501,800.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 344,561,791.30 | 340,315,406.78 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 340,490,251.30 | 338,218,443.78 |

| | | | |
|---|---|---|---|
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 4,071,540.00 | 2,096,963.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,569,009,788.45** | **7,855,137,768.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 6,569,009,788.45 | 7,855,137,768.39 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 5,590,183,039.77 | 5,590,183,039.77 |
| 51101 | Өмч: - төрийн | 5,590,183,039.77 | 5,590,183,039.77 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (48,384,988.65) | 1,237,742,991.29 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (48,384,988.65) | (49,093,211.65) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 1,286,836,202.94 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,027,211,737.33 | 1,027,211,737.33 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **9,268,744,580.84** | **13,427,930,840.54** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **17,684,318,571.06** | **23,895,872,860.42** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,609,149,218.15** | **8,106,999,279,31** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **2,609,149,218.15** | **8,106,999,279,31** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,385,060,239.05 | 1,410869,942,08 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 603,275,897.08 | 544,742,067.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 781,784,341.97 | 866,127,875.08 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/үндсэн хөрөнгө/ | 329,416,263.38 | 5,670,467,351.36 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/бараа материал/ | 894,672,715.72 | 1,039,128,144.91 |
| 120009 | Бусад орлого | | 183,513.96 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **15,075,169,352.91** | **15,788,873,581.11** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **310,603,445.91** | **357,483,734.11** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 310,603,445.91 | 357,483,734.11 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **14,764,565,907.00** | **15,431,389,847.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 14,764,565,907.00 | 15,431,389,847.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **20,189,932,563.20** | **22,622,686,330.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **20,189,932,563.20** | **22,622,686,330.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **19,656,696,247.12** | **22,298,795,389.01** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **11,638,110,244.28** | **12,787,474,319.96** |
| 210101 | Үндсэн цалин | 5,618,468,531.95 | 6,461,711,031.55 |
| 210102 | Нэмэгдэл | 4,093,376,012.46 | 3,626,047,113.07 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,112,331,932.97 | 1,806,592,000.00 |
| 210104 | Урамшуулал | 813,933,766.90 | 893,124,175.34 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,265,723,661.19** | **1,579,160,111.56** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 892,981,997.30 | 1,070,417,774.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 93,185,065.96 | 130,254,012.93 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 46,592,832.99 | 90,917,495.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 46,592,832.99 | 57,142,736.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 186,370,931.95 | 230,428,091.32 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **310,603,445.91** | **357,483,734.11** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 111,027,554.09 | 154,448,334.27 |
| 210302 | Түлш, халаалт | 85,631,504.27 | 100,423,976.08 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 85,412,677.55 | 79,963,423.76 |
| 210304 | Байрны түрээс | 28,531.710 | 22,648,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **355,664,214.89** | **1,074,406,658.98** |
| 210401 | Бичиг хэрэг | 37,193,760.00 | 36,733,368.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,000,656.74 | 26,146,225.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 20,772,029.16 | 22,091,461.44 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 130,256,136.56 | 157,486,050.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 150,441,632.43 | 419,662,987.23 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 412,286,567.31 |
| **2105** | **Нормативт зардал** | **4,262,757,013.42** | **4,327,495,324.91** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,748,323,222.67 | 3,839,312,774.91 |
| 210502 | Хоол, хүнс | 514,337,790.75 | 485,756,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 96,000.00 | 2,425,750.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **32,345,305.000** | **60,584,698.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 7,260.00 |
| 210604 | Урсгал засвар | 32,345,305.000 | 60,577,438.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **392,930,924.00** | **569,365,695.05** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 361,689,273.00 | 510,156,600.03 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 8,006,900.00 | 7,600,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,488,220.00 | 5,490,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 499,552.00 | 1,325,756.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.000 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,284,500.00 | 24,728,837.02 |
| 210807 | Газрын төлбөр | 3,588,949.00 | 4,537,832.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 12,318,530.00 | 15,449,670.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,398,561,438.43** | **1,542,824,846.44** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 47,759,750.53 | 99,038,637.88 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 880,000.00 | 2,664,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,349,921,687.90 | 1,441,122,208.56 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **533,236,316.08** | **323,890,941.47** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **533,236,316.08** | **323,890,941.47** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 516,182,389.88 | 299,867,441.47 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,053,926.20 | 24,023,500.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-2,505,613,992.14** | **1,286,836,202.94** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-2,505,613,992.14** | **1,286,836,202.94** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **17,361,708,237.22** | **17,090,009,769.56** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,385,060,0239.05** | **1,130,944,864.02** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,385,060,239.05** | **1,130,944,864.02** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,385,060,239.05** | **1,130,421,350.06** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 603,275,897.08 | 544,230,441.50 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 781,784,341.97 | 812,942,325.56 |
| 120009 | Бусад орлого | | 523,513.96 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **15,976,647,998,67** | **15,732,313,488.54** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **310,603,445.91** | **357,483,734.11** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 310,603,445.91 | 357,483,734.11 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **15,666,044,552.76** | **15,374,829,754.43** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 15,666,044,552.76 | 15,374,829,754.43 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **17,463,015,428.31** | **16,950,063,243.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **17,463,015,428.31** | **16,950,063,243.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **16,929,779,112.23** | **16,626,172,302.35** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **11,805,957,431.23** | **11,275,015,508.24** |
| 210101 | Үндсэн цалин | 5,767,351,021.31 | 5,465,772,449.51 |
| 210102 | Нэмэгдэл | 4.112,340,710.05 | 3,268,393,913.56 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,112,331,932.97 | 1,646,001,563.38 |
| 210104 | Урамшуулал | 813.933.766.90 | 894,847,581.79 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,265,723,661.19** | **1,134,768,642.28** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 892,981,997.3 | 913,782,746.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 93,185,065.96 | 85,927,268.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 46.595.832.99 | 47,597,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 46.595.832.99 | 47,597,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 186,370,931.95 | 39,863,227.22 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **313,594,445.91** | **357,483,734.11** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 111,027,554.09 | 154,448,334.27 |
| 210302 | Түлш, халаалт | 91,949,913.96 | 100,423,976.08 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 79,094,267.86 | 79,963,423.76 |
| 210304 | Байрны түрээс | 31,522,710.00 | 22,648,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **252,326,694.30** | **397,640,301.44** |
| 210401 | Бичиг хэрэг | 24,645,000.00 | 38,736,428.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,227,300.00 | 30,157,625.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 20,172,029.16 | 25,865,838.44 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 106,387,085.14 | 159,582,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 91,895,280.00 | 143,297,810.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **2,739,370,244.48** | **2,616,101,330.86** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,424,487,694.48 | 2,264,077,530.86 |
| 210502 | Хоол, хүнс | 290,082,550.00 | 340,023,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 24,800,000.00 | 12,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **179,637,240.00** | **107,377,870.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 141,751,240.00 | 76,256,920.00 |
| 210604 | Урсгал засвар | 37,886,000.00 | 31,120,950.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **279,641,054.00** | **640,266,132.35** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 249,931,273.00 | 579,944,446.33 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 7,586,900.00 | 7,600,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,448,220.00 | 5,490,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 499,552.00 | 1,263,656.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,491,160.00 | 30,500,460.02 |
| 210807 | Газрын төлбөр | 3,588,949.00 | 3,720,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 6,000,000.0 | 11,670,570.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **93,528,341.12** | **97,518,783.07** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 92,648,341.12 | 94,951,783.07 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 880,000.00 | 2,567,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **533,236,316.08** | **323,890,941.47** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **533,236,316.08** | **323,890,941.47** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 516,182,389.88 | 299,867,441.47 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,053,926.20 | 24,023,500.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(101,307,190.59)** | **139,946,525.74** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **68,719,100.00** | **17,787,670.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **68,719,100.00** | **17,787,670.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **68,719,100.00** | **17,787,670.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 68,719,100.00 | 17,787,670.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(68,719,100.00)** | **(17,787,670.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **(170,026,290.59)** | **122,158,855.74** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **10,011,674.04** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **10,011,674.04** | **132,170,529.78** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 5,590,183,039.77 | 2,190,374,912.29 | 2,457,229,003.49 | 10,237,786,955.55 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,590,183,039.77** | **2,190,374,912.29** | **2,457,229,003.49** | **10,237,786,955.55** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | (1,163,163,174.96) | - | (1,163,163,174.96) |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (2,505,613,992.14) | (2,505,613,992.14) |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,590,183,039.77** | **1,027,211,737.33** | **(48,384,988.65)** | **6,569,009,788.45** |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **5,590,183,039.77** | **1,027,211,737.33** | **(48,384,988.65)** | **6,569,009,788.45** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (708,223.00) | (708,223.00) |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,590,183,039.77** | **1,027,211,737.33** | **(49,093,211.65)** | **6,568,301,565.45** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 1,286,836,202.94 | 1,286,836,202.94 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,590,183,039.77** | **1,027,211,737.33** | **1,237,742,991.29** | **7,855,137,768.39** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Ерөнхий данс | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **Татаас, санхүүжилтийн орлого** | 15,728,498,900.00 | 15,732,313,488.54 | (3,814,588.54) | 100.0 |
| | Улсын төсвөөс | - | - | - | - |
| | Урсгал | - | - | - | - |
| | Хөрөнгийн | - | - | - | - |
| | Нөөц сангаас | - | - | - | - |
| 131001 | Орон нутгийн төсвөөс | 641,263,100.00 | 357,483,734.11 | 283,779,365.89 | 55.7 |
| | Бусад төсөвт байгууллагаас | - | - | - | - |
| 134002 | Нийгмийн даатгалын сангаас | 15,087,235,800.00 | 15,374,829,754.43 | (287,593,954.43) | 101.9 |
| | Бусад тусгай зориулалтын сангаас | - | - | - | - |
| | Тусламжийн орлого | - | - | - | - |
| **120** | **Бараа, үйлчилгээний орлого** | - | - | - | - |
| | Өмчийн орлого | - | - | - | - |
| 120004 | Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 998,973,700.00 | 1,357,172,767.06 | (358,199,067.06) | 135.8 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 658,328,000.00 | 544,230,441.50 | 114,097,558.50 | 82.6 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 340,645,700.00 | 812,942,325.56 | (472,296,625.56) | 238.6 |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **16,791,642,700.00** | **17,009,009,769.56** | **(362,537,169.56)** | **102.1** |
| **2100** | **Ажиллагчидтай холбогдсон зардал** | **12,026,528,700.00** | **12,409,784,150.52** | **(383,255,450.52)** | **103.2** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **11,281,653,100.00** | **11,275,015,508.24** | **6,637,591.76** | **99.9** |
| 210101 | Цалин | 6,152,603,500.00 | 5,465,772,449.51 | 686,831,050.49 | 88.8 |
| 210102 | Нэмэгдэл | 3,500,801,000.00 | 3,268,393,913.56 | 232,407,086.44 | 93.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 685,656,100.00 | 1,646,001,563.38 | (960,345,463.38) | 240.1 |
| 210104 | Урамшуулал | 942,592,500.00 | 894,847,581.79 | 47,744,918.21 | 94.9 |
| **2102** | **Нийгмийн хамгааллын шимтгэл** | **744,875,600.00** | **1,134,768,642.28** | **(389,893,042.28)** | **152.3** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 389,055,100.00 | 913,782,746.86 | (524,727,646.86) | 234.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 113,955,100.00 | 85,927,268.20 | 28,027,831.80 | 75.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 56,977,600.00 | 47,597,700.00 | 9,379,900.00 | 83.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 56,977,600.00 | 47,597,700.00 | 9,379,900.00 | 83.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 127,910,200.00 | 39,862,227.22 | 88,036,972.78 | 31.2 |
| | **Бараа ,үйлчилгээний урсгал зардал** | **504,499,900.00** | **334,835,734.11** | **169,664,165.89** | **66.4** |
| 2103 | **Тогтмол зардал** | **504,499,900.00** | **334,835,734.11** | **169,664,165.89** | **66.4** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 207,722,600.00 | 154,448,334.27 | 53,274,265.73 | 74.4 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 178,098,100.00 | 100,423,976.08 | 77,674,123.92 | 56.4 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 118,679,200.00 | 79,963,423.76 | 38,715,776.24 | 67.4 |
| **2105** | **Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал** | **2,566,624,100.00** | **2,604,101,330.86** | **(37,477,230.86)** | **101.5** |
| 210502 | Хоол | 462,047,600.00 | 340,023,800.00 | 122,023,800.00 | 73.6 |
| 210501 | Эм | 2,104,576,500.00 | 2,264,077,530.86 | (159,501,030.86) | 107.6 |
| | **Бусад бараа үйлчилгээний зардал** | **1,794,866,900.00** | **1,619,129,698.33** | **178,737,200.67** | **90.2** |
| 210401 | Бичиг хэргийн материал | 37,716,500.00 | 38,736,428.00 | (1,019,928.00) | 102.7 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 32,921,300.00 | 30,157,625.00 | 2,763,675.00 | 91.6 |
| 210403 | Шуудан холбооны зардал | 24,600,000.00 | 25,865,838.44 | (1,265,838.44) | 105.2 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 3,140,000.00 | 2,567,000.00 | 573,000.00 | 81.8 |
| 210406 | Жижиг эд хогшил худалдан авах зардал | 143,969,800.00 | 143,297,810.00 | 671,990.00 | 99.5 |
| 210503 | Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал | 12,000,000.00 | 12,000,000.00 | - | 100.0 |
| 210807 | Төлбөр, хураамж, жижиг татварууд | 3,720,000.00 | 3,720,000.00 | - | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 7,600,000.00 | 7,600,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,490,000.00 | 5,490,000.00 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,900,000.00 | 1,263,656.00 | 636,343.00 | 66.5 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 130,000.00 | 77,000.00 | 53,000.00 | 59.2 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 40,052,000.00 | 30,500,460.02 | 9,551,539.98 | 76.2 |
| 210801 | Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 596,737,900.00 | 579,944,446.33 | 16,793,453.67 | 97.2 |
| 210809 | Маягт хэвлүүлэх зардал | 11,674,000.00 | 11,670,570.00 | 3,430.00 | 99.9 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 91,844,500.00 | 94,044,590.00 | (2,200,090.00) | 102.4 |
| 210604 | Урсгал засвар | 29,903,700.00 | 31,120,950.00 | 99,659,650.00 | 23.8 |
| 210405 | Бусад зардал | 160,086,000.00 | 159,582,600.00 | 503,400.00 | 99.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусадзардал | 109,784,500.00 | 94,951,783.07 | 14,832,716.93 | 86.5 |
| 210304 | Байрны түрээсийн зардал | 23,000,000.00 | 22,648,000.00 | 352,000.00 | 98.5 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 332,827,200.00 | 299,867,441.47 | 32,959,758.53 | 90.1 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал, урамшуулал | 24,892,600.00 | 24,023,500.00 | 869,100.00 | 96.5 |
| 225501 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал | - | -17,787,670.00 | - | 100.0 |
| | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **16,791,642,700.00** | **16,967,850,913.82** | **(75,331,313.82)** | **101.1** |
| 31 | Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 10,011,674.04 | (10,011,674.04) | - |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 132,170,529.78 | (132,170,529.78) | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0 | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0 | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 256 | 211 | 45 | 82.4 |
| 620001 | Удирдах ажилтан | 2 | 2 | 0 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 211 | 172 | 39 | 81.5 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 43 | 37 | 6 | 86.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 256 | 211 | 45 | 82.4 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 186 | 159 | 0 | 85.5 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 70 | 52 | 0 | 74.3 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,649.7 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснээс аудитын явцад 13,649.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Бараа материалыг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэхдээ "Үнэ төлбөргүй орлого" дансанд 13,649.7 мянган төгрөгийн орлого бүртгэж, дансны бичилт буруу хийсэн нь УСНББОУС-1, “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 127,314.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 52,556.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 74,757.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 127,314.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 98,912.9 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

Тайлант онд 52,556.5 мянган төгрөгийг шүүхийн шийдвэрээр нэхэмжлэгчид олгож, авлага үүсгэсэн боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1.”Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.” заалттай нийцэхгүй байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн шийдвэрээр нөхөн олговор олгоод авлага үүсгэсэн боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөв.

НДШ, ХХОАТ-ын өр төлбөр оны эхний үлдэгдлээс 5.1 дахин өссөн нь ЭМДС-гийн санхүүжилтийн гэрээний дүн багаар хийгдсэн, төсөвт тавигдсан зардлын зарцуулах эрх хүрэлцээгүй, төлөвлөгөөт архагын оношны 20.0 хувийн хасагдалаас тус тус шалтгаалсан байна байна. ХХОАТ-ын 4-12 дугаар сарын, НДШ-ийн 6-12 дугаар сарын өр төлбөрийг төсөвт төлж барагдуулаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн *27 дугаар зүйлийн 27.1-д "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1, 20.4-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ."* Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн *21.1-д "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө"* гэж заасантай нийцэхгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын болон Нийгмийн даатгалын өр төлбөрийг хуульд заасан хугацаанд төсөвт төвлөрүүлээгүй зөрчлийг зогсоох албан шаардлага өгөв.

**5.2 Зөвлөмж**

**1.Авлагатай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

ЭМДС-гаас авах авлагаас эмчийн хасагдуулгаар 74,757.5 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.2-т "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах", 13.1.4-д "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх", 13.1-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: ЭМДС-гаас авах авлагаас хийгддэг хасагдуулга, түүний дотор эмчийн хасагдуулгыг өмнөх оноос 20-иос доошгүй хувиар бууруулж, орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалыг Үндсэн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэхдээ "Үнэ төлбөргүй орлого" дансанд бүртгэж, дансны бичилт буруу хийсэн. | 1 | 13,649.7 | | | 1 | 13,649.7 | 1 | 13,649.7 | | | | |
| Дүн | 1 | 13,649.7 | | | 1 | 13,649.7 | 1 | 13,649.7 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 2023, 2024 онуудад зөвхөн Үндсэн тусламж үйлчилгээний хасагдал хийдэг байсан учир 2025 оны Үндсэн тусламж үйлчилгээний хасагдал 282,252.4 мянган төгрөгийг 2023 онтой харьцуулахад 79.2 хувиар , 2024 онтой хувиар харьцуулахад 31.3 хувиар буурсан байна. Эмчийн хасагдуулга 74,757.5 мянган төгрөг байна. Энэ нь нийт нэхэмжилсэн дүнгийн 0.4 хувийг эзэлж байна. | 1 | 74,757.5 | | | | | 1 | 74,757.5 | | | | |
| Тайлант онд 52,556.5 мянган төгрөгийг шүүхийн шийдвэрээр нэхэмжлэгчид олгож, авлага үүсгэсэн байна. Гэвч олгосон нөхөн олговрыг буруутай | 1 | 52,556.5 | | | 1 | 52,556.5 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна. | | | | | | | | | | | | |
| Татварын болон Нийгмийн даатгалын өрийг төлөөгүй | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| Дүн | 3 | 127,314.0 | | | 2 | 52,556.5 | 1 | 74,757.5 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Цахим дэлгүүрт байршсан 14,119.5 мянган төг-ийн тоног төхөөрөмжийг бусад этгээдээс худалдан авалт байна. | 1 | 14,119.5 | | | 1 | 14,119.5 | | | | | | |
| Дүн | 1 | 14,119.5 | | | 1 | 14,119.5 | | | | | | |